

III. Намтар судлал, түүхэн хүн судлалын асуудлууд

МОНГОЛЫН ТӨР БА АХМАД ҮЕ

Ж.Болдбаатар

Монгол Улсын Их Сургууль. Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль. Түүхийн Тэнхим

Өгүүллийн товч утга: Монголын төр түүхийн бүхий л туршид ахас, ихэсийнхээ үгийг анхааралтай сонсож, тэдний туршлага, зөвлөлгөө авч, төрийн бодлогод тусгаж иржээ. Эл санааг уг өгүүлэлд түүхэн сурвалж, баримт сэлтээр нотлон өгүүлэх болно.

Түлхүүр үг: ахмад, идэр, залуу, ахас, ихэс, өтөл буурай туршлага, тулх ухаан, залгамж халаа, партизан, ахмад зүтгэлтэн

Хүн төрөлхтөний түүх цадиг бол ахмад, идэр, залуу, өсвөр үеийнхний залгамж үеийн түүх бөгөөд тэрхүү залгамж чанар нь нийгмийн бүх үзэгдлийг нэгдмэл түүхэн төлөв байдалд авч үзэх боломж олгодог. Бүр ураг төрлийн байгууллын үед овог, аймгийн дотор гарсан зөрөлдөөн, ёс бус явдлыг ахмад настны хуралдаанаар хэлэлцэн шийддэг эрхэм ёсон байсныг түүх шаштираас бид мэднэ.

Төр ёс үүссэн үед ч төрийн тэргүүн-хаан, ахмад настан, ахас ихсийн үгийг анхааралтай сонсч, тэдэнтэй төр, түмний өмнө тулгамдсан амин чухал асуудлыг зөвлөн шийдвэрлэдэг уламжлал байсаар байв. Өвөг Монгол улсуудын үед ноёлох овгийнхны дотроос сахилга, дэг журам алдаж, хэрэг түвэгт орооцолдсон хүмүүсийг ахмадын зөвлөлөөр оруулж, ялалж, буруушааж, гэм нүглийг нь ойлгуулж байсан баримт тааралддаг. Л.Н.Гумилев өөрийнхөө бүтээлд “Сяньби нарын өвөг Дунху аймгийнхан ахмадын зөвлөлийг сонгон ажиллуулж байсан. Хүннүгийн 24 түмтэд ахмадын зөвлөл хаанд зөвлөх эрхтэйгээр ажиллаж байсан” тухай тэмдэглэжээ.

Их Монгол улс, Эзэнт гүрний үед үлэмжийн их Чингис хаан, түүнийг залгамжлагчид ахмад үеийн туршлагадаа тулгуурлаж, тулх ухаандаа богшоон, тансаг хэлэндээ ширгээж хэлсэн үгийг туйлын анхааралтай сонсон болгоож байсан бүлгээ. Эзэн Богд Чингис хаан ахмад үедээ нэн хүндэтгэн хандаж байсан олон жишээ бий. Чингис хаан: “Би өвөг дээдсийнхээ газар нутаг, орон өргөөг алга болгоход хүргүүлэхгүй. Би тэдний ёс заншил, зам мөрийг устгуулахгүй” (1,243) гэж мэдэгдээд “Өвгөдийн үгийг өв болгож яв... Түмэн хүнээс ёс мэдэх нэг хүн дээр байдаг. Өтлийг бүү хилэгнүүл” (2.126) хэмээн захиж байлаа. Түүнчлэн “Ахмад настан дээр очиж буй хэн ч урьтаж дуугарахгүй, түүнийг асуухаас өмнө юу ч хэлэх учиргүй, түүнийг асуусны дараа хариуг хэлж бай” (1,404) сургамжилж байлаа.

Чингис хаан ахмад настны мэдлэг туршлагыг ашиглахын тул тэднийг хаан төрдөө санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжоор хангаж байсан юм. Тэрбээр: “Бид хадаас болж, төрийг бэхлэн сахиж, аргамж болж, улсыг барин хатуужив. Өтгөс минь Та нар өөрийн тусыг бодолгүй улсын тулд өгүүлж, зөвлөж байхтун” (2, 140) хэмээн уриалж байв.

Их Монгол улс ахмад настныг дараах хэд хэдэн чиглэл, арга барилаар төр, түмний үйлсэд итгэмжлэн зарж, хөхиүлэн дэмжиж байсан байна. Үүнд:

1. Ахмад настныг өтөл буурай болсон гэлгүй эрдэм чадалтай заримыг нь насан огштол төрийн албанд зүтгүүлж, тэдний амьдралын туршлага, цөлх ухааныг ашиглаж байжээ. “Монголын нууц товчоо”-ны 216 дугаар зүйлд: “...Чингис хаан Үсүн өвгөнд өгүүлрүүн: “Үсүн, Гунан, Хөхөчос, Дэгэй эд дөрөв

Үзсэн сонссоноо

Үл нуун хавчиж

Өгүүлж зааж байх бүлгээ

Ухсан сэтгэснээ

Уламжлан хэлж байх бүлгээ

Монголын төр, ноён мөр

Бэхи болохуй ёсон ажгуу

Баарин ахын ураг бүлгээ

Бэхи мөр бидний дотор дээрээс

Бэхи Үсүн өвгөн болтугай!

Бэхи өргөөд цагаан аюе өмсөж, цагаан агт унуулж, суурь дээр суулган тахиж, бас он сар саатан тийн атугай” хэмээн зарлиг болгов”.(3.252) гэжээ.

Сайхь өндөр настан тэнгэр огторгуйг шинжиж, он жил, сар өдрийг заасан хуанли зохиож, наран, саран хиртэхийг эртнээс мэдэж хаан эзэндээ айлтгах, дайлаар мордох, Их Хуралдай чуулах өлзий дэмбэрэл бүрдсэн өдөр цагийн сайныг тогтоон тодорхойлох үндсэн үүрэг гүйцэтгэж, монголын төрд олон жил ээлээ өгчээ.

Улсын их заргач Шихихутуг 82 нас, Чангай чинсан, Елюй-Чуцай, Тататунга нар дал гартлаа төрийн хэрэгт хичээнгүйлэн зүтгэж байлаа.

2. Их хуралдай, Сэцдийн зөвлөлийн бүрэлдхүүнд ахмад настнуудыг оруулж, тэдний санал бодол, зөвлөгөөг анхааралтай сонгон, аль болохоор амьдралд

хэрэгжүүлэхийг эрхэмлэж байлаа. Өгэдэй хааны үед ахмадуудын мэдлэг, чадвар туршлагыг ашиглах талаар илүү өгөөжтэй зүйл хийж байсан байна.

3. Чингис хаан өтөл буурал өвгөн эрдэмтэн, гүн ухаантныг Эзэнт гүрний аль хязгаарт байх нь хамаагүй урьж залж, учиртай үгийг нь сонсож, ухаанаа ирлэж байжээ. Тухайлбал, Хятадын өвгөн эрдэмтэн Чань Чунь бумбыг хэд дахин төлөөлөгч илгээн, алс холоос олон хоног сараар аялуулан урьж, авчраад, Баруун Алтайн Киндикүш уулан дахь аяны ордондоо хүлээж авч, тухлан ярилцсан юм. Их хаан түүнтэй урт наслах боломж, төр засах ухааны талаар зөвлөн ярилцжээ. Тэдний хөөрөлдөөний нэгэн хэсгээс толилуулбал, Чингис хаан:

- Улсыг засахад тун хүчир бэрх. Миний сэтгэл хүчнийг зовоож байна хэмээн айлдахад Чань Чунь:

- Их улсыг засах нь бяцхан жараахай шарах лугаа адил. Хэт чанга үрвэл мах нь үлдэхгүй унана. Бага шарвал түүхий. Хэт шарвал түлэгдэнэ. Улсыг зарах нь үүн лүгээ адил. Ямагт хэрсүү хичээнгүй болгоомжтой байх нь чухал хэмээв. Чингис хаанд эл үг таалагдсан бололтой дахин асууруун:

- Нэгэнт байгуулагдсан их улс гүрнийг удаан тогтоон барих ямар арга байна гэхэд Чань Чунь бодлогшроод:

- Догшин салхи өдөр турш үргэлжилдэггүй. Аадар бороо ч өдөр турш ордоггүй. Тэнгэр, газар ч салхи бороог цагаар захирч чадахгүй байтал хүн яахин өөрийн дураар байж чадах билээ. Аливаа юмс тэнгэрийн тааллаас шалтгаална хэмээн айлджээ. (4.204) Энэ мэтээр айлдсныг Их хаан монгол, хятад бичгээр буулган хадгалах, төрийн түшээ нар сургамж, санамж авахыг тушааж байлаа.

4. Монголын хаад баяр ёслол, онцгой тэмдэглэлт өдрүүдээр ахас ихсийн сургаал, саналыг сонсохын зэрэгцээ хүндэтгэлийн хишиг хүртээдэг уламжлалтай байв. Энэ тухайд дараах нэгэн баримтыг сөхөж болох юм.

“Улаан хулгана жил их Монгол улсын 11 он. Чингис хаан 55 нас сүүдэртэй байхдаа Цагаан сарын шинийн нэгэнд барс цагт (03.40-05.40) дээшилж, луу (7.40-9.40) цагт эрдэнийн суудалд залран сууж, зуун түшмэд мөргөж дууссаны хойно зарлиг болруун:

“Орчлонгийн хооронд хүн төрөлхтний хочгүй ойр янаг хэмээгч эцэг эх, толгой тэргүүн, ах дүү хэмээгч гар хөл, эм үр хэмээгч дээл хувцад, сайд түшмэд хэмээгч хуяг дуулга зэр зэвсэг мэт буюу. Энэ өдөр би хүний эшийн ёсоор эхлэн ялгасугай: тэргүүнд миний хаан эцгийн байдал дүрсийг алтаар бүтээж Тай Мяо-д

(их сүм хэмээх хятад үг.хөр) тахь, жич миний эх тайхуу нас сүүдэр далан долоод хүрч, сүүдэр маш өндөр болсон тул их хүүгээс шар алт мянган лан, цагаан мөнгө түмэн лан, зотон бөс арван түмэн хэсэг, миний харъяат найман зуун ерэн хоёр хот балгадын сан хөмрөгийг нээж гарган, миний харъяат улсын жаран наснаас дээшид дан хувь, ерэн наснаас дээшид дөрвөн хувь, зуун наснаас дээшид таван хувь, зуун арван наснаас дээшийг надад бараадуул, өвөрмөц шагнамуу. Зуун хорин наснаас дээшийг олмогц урьд улсын Го лао (улсын өтгөс хэмээх үг.хөр) цол өргөж, таяг тулуулан надад бараадуул, өөр өргөмжлөл буй. Хэрэв үүнээс давагсад аваас цөм сүйхэд суулган дамнан ирүүлж бараадуул, ангид ялгал буй. Энэхүү нэг нэг хувьд нэг лан мөнгө нэг толгой бөс арван суулга амууг хэмжээ болго. Наян нас гарсанд шар алт нэг цэн нэмж өг. Үүний дотор ховдог ард нас өсгөж хишгийг мэхлэгчид ахуу болзошгүй, эрхбиш түүний төрөл төрөгсөд ураг садан айл аймаг зэргэлдээ айлаас хянан байцааж, тодорхойл." (5.82-83) гэжээ. Үүнээс үзэхүл, 120-иос дээш насалсан өндөр настанд улсын Го лао буюу Улсын өтгөс цол шагнаж, тусгай өргөмжлөл олгож байжээ.

Ер нь үлэмжийн их Чингис хаан өтгөс өвгөдөө хүндлэн өргөмжлөх, хойчис нялхсаа хайрлан асрагчдыг хамгаас түрүүн хөхиүлэн дэмжиж байжээ.

Чингис хаан хөвгүүдтэй ярилцаж суугаад:

- Жаргалын сайн нь юу вэ? хэмээн асуухад Өгэдэй:

- Төр ёсоо түвшин барьж, өтгөс ихсийг жаргуулж, өсөх залуусыг амаржуулваас жаргалын сайн нь энэ билээ хэмээн хариулсныг ихэд таашаан хүлээж авч, сэтгэл хангалуун байсан гэдэг.

• Төрийн хэрэгт ахмадыг татан оролцуулах, тэднийг хүндэтгэх, халамжлах Чингис хааны бодлого, уламжлал дараа дараагийн үеийн Монголын төрийн бодлогод уламжлан ирсэн байна. Тухайлбал, 1911 оны үндэсний хувьсгалын үр дүнд тусгаар тогтнолоо дахин сэргээснээ тунхаглаад VIII Богд Жибзундамба хаан анхныхаа зарлигтаа:

"Далан наснаас дээш наян нас хүртэлх хөгшдөд мөнгө гурван лан. Наян наснаас дээш, ерэн нас хүртлэхэд зургаан лан, 90 наснаас дээш 100 насанд хүрснийг нь мэдүүлэн ирүүлээд жич өршөөн шагнахыг үзүүлтүгэй" (7.145) хэмээжээ.

Богд хаан өөрөө настнуудыг хүндэтгэдэг, уулзаж, зөвлөдөг, тэдэнд мутрын адис хайрлах дуртай өр нимгэн, нигүүлсэнгүй хүн байжээ. 1921 оны үндэсний

ардчилсан хувьсгалын дараа ч хэмжээт эрхт Богд хаан түүхэн тэмдэглэлт үйл явдал, баяр ёслолын үеэр ахмад настанд хүндэтгэл үзүүлэх, хишиг хүртээх саналыг Ардын засгийн газар оруулж, шийдвэрлүүлж байлаа. Түүнчлэн төрийн ахмад зүтгэлтнүүд залгамж үеэ бэлтгэдэг түүхэн уламжлал өвлөн хадгалагдаж байсан гэж үзэж болох юм. Энд тэмдэглэхэд, чин ван М.Ханддорж, хичээнгүй сайд Б.Цэрэндоржийг, Цэрэндорж А.Амарыг, Амар С.Довчинг тус тус өөрийнхөө оронд бэлтгэж байсан гэдэг.

Ардын засгийн жилүүдэд төв, орон нутгийн засаг захиргааны ажилд ахмад үеийн мэдлэг, чадвар, туршлагыг ашиглах, тэдэнд халамж үзүүлэх, тэтгэмж олгох зэргээр урьд өмнө хэзээ ч тавигдаж байгаагүй ихээр анхаарсан бөгөөд чингэх эрх зүйн үндсийг ч бүрдүүлж эхэлсэн байна.

БНМАУ-ын Бага хурал, Засгийн газрын хамтарсан 1931 оны VII сарын 4-ний өдрийн 18 дугаар хурлаар жанжин Г.Дэмидийн илтгэлийг хэлэлцээд, 1921 оны хувьсгалын үйл хэрэгт гар бие оролцсон хүмүүсийг ардын хувьсгалын улаан партизан хэмээн нэрлэн тэдэнд "Тэтгэвэр хөнгөвчлөл олгох дүрэм"-ийг батлан гаргаж, хэрэгжүүлжээ. (8) Улмаар хувьсгалт цэргийн зөвлөлийн дэргэд Партизаны комиссыг жанжин Г.Дэмидээр толгойлуулан байгуулсан байна. Тус байгууллага олон талт ажил зохиож, улам бүр институтжиж байв. Ийм учраас л комисс байгуулагдаж, үйл ажиллагаа явуулснаар Монголын ахмадын байгууллагын суурь тавигдсан хэмээн үзэж болох юм.

1941 оны XI сарын 26-ны өдрийн БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 85 дугаар тогтоолоор Партизануудын хэргийг тусгайлан эрхлэх байнгын комиссыг Бага Хурлын тэргүүлэгчдийн дэргэд байгуулж, комиссын даргаар Улсын Бага Хурлын тэргүүлэгч гишүүн, партизан Д.Дашзэвгийг батлажээ. (9) Эл комисс партизаны дүрмийг шинэчлэх 1921 оны хувьсгалын үйл хэрэгт оролцож явсан хүмүүсийг тодруулан бүртгэж, үнэлэх шийтгэх, партизануудад байнгын болон нэг удаагийн мөнгөн тэтгэвэр, тэтгэмж олгох, амралт сувилалд жилд нэг удаа үнэ төлбөргүй амруулах, тусгай эмнэлэгт үзүүлэх зэргээр халамж үйлчилгээ үзүүлэх, ёслолын хувцастай болгох, орон нутагт явах унааны зардлыг олгох, төрийн дээд шагнал-одон, медалиар шагнуулах зэрэг олон арга хэмжээг төр засагт асуудал тавих замаар шийдвэрлүүлсэн байна.

МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны 1968 оны 93-р тогтоолоор БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дэргэдэх Партизаны хэрэг эрхлэх

комиссыг өөрчлөн өргөтгөж, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн газрын дэргэдэх Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хороо байгуулахаар тогтсон байна. Энэ тогтоолоор тус хорооны үүргийг дор дурьдсан байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Хөдөлмөрчид, залуу үеийг эх оронч, хувьсгалт дайчин уламжлалаар хүмүүжүүлэх хэрэгт ахмад үеийнхний хүчийг зохион байгуулж идэвхтэй оролцуулах,

2. Улс түмнүүдийн хооронд энх тайван, найрамдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын ба үндэсний байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, хамтарч ажиллах,

3. 1921 оны ардын хувьсгалын партизан, гадаад дотоодын дайснаас эх орноо хамгаалах үйл хэрэгт биеэр оролцож гарамгай гавъяа байгуулсан зэвсэгт хүчний цэрэг, түрүүч, офицер, генералууд, нам төр, олон нийт аж ахуй, соёлын байгууллагуудын ажилтан, тус улсын болон бусад орны иргэдийг байгуулсан гавъяа, баатарлаг үйлсээр нь шалгаруулан бүртгэж, тэднийг хөдөлмөрчдийн дунд явуулж, хүмүүжлийн болон улс төр, олон нийтийн ажилд татан оролцуулах явдал гэж заажээ. (10.23) Тус хорооны анхны даргаар хошууч генерал Ж.Цэнд-Аюушийг батлажээ. Чингэснээр Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний хорооны ажил үйлс өмнөх үеэс өргөжиж, илүү олон ахмад настныг хамарсан үйл ажиллагаа явуулсан байна. Төрийн ивээл, дэмжлэгээр тус байгууллага хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтнүүдийг тодруулах, хүндэт тэмдэг бий болгох, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, Халх голын ялалт, Чөлөөт дайны ойгоор тойрон аялал хийх, Монгол, Зөвлөлтийн ахмад дайчдын чуулга уулзалт зохиох, партизан болон ахмад үеийн дуртгал, дурсамж хэвлүүлэх зэргээр залуу үеийг ахмад үеийн баатарлаг дайчин, хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлэх хэрэгт зохих хувь нэмрээ оруулсан байна.

1980-аад оны сүүлч 1990 оны эхээр Монгол улс хөгжлийн шинэ сонголт хийж, ардчилал, зах зээлд шилжин орсон юм. Ийм үед ахмадын байгууллагын үйл ажиллагааны агуулга, цар хүрээг өргөжүүлэх нь зүйтэй гэж үзээд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчоо 1988 оны III сарын 21-нд 58 дугаар тогтоол гаргаж, Монголын ахмадын холбоог байгуулахаар шийдвэрлэжээ.

Монголын ахмадын холбоог зохион байгуулах бага хурал 1988 оны III сарын 25-нд хуралдаж, ардын хувьсгалын партизан, хувьсгалт тэмцлийн болон хөдөлмөрийн нийт ахмадууд, ахмад дайчдыг эгнээндээ нэгтгэсэн өргөн олон нийтийн байгууллага-Монголын ахмадын холбоог байгуулснаа зарлажээ. Тус холбооны гүйцэтгэх хорооны анхдугаар хурлаар 15 хүнийг тэргүүлэгчээр, гүйцэтгэх

хорооны даргаар Ө.Чойжилсүрэнг батлажээ. Тэр цагаас хойш Монголын ахмадын холбоо 4 удаа (1991,1995,1998,2002) их хурал буюу чуулганаа хийж, ахмад настны тухайн тулгамдсан асуудлыг хэлэлцэж, төр засагтаа тавьж шийдвэрлүүлжээ. Үүнд: юуны өмнө, 1992 онд “Монголын ард түмний ахмад үеийн талаар баримтлах төрийн бодлогын тухай” БНМАУ-ын Ерөнхийлөгч зарлиг буулгасан, 2004 онд УИХ Монгол улсын Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогод “Ахмад настны талаар Монгол Улсын төрөөс баримтлах бодлого”-ыг тусгайлан оруулж баталсан болой. Түүнчлэн 1995 онд УИХ “Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлтийн тухай” Монгол Улсын хуулийг баталж хэрэгжүүлэн, улмаар 2005 онд түүний агуулга, цар хүрээг өргөтгөн, “Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хууль болгон баталжээ. Эдгээр хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын Засгийн газар Ахмадын байгууллага, ахмад настануудын талаар цогцолбор арга хэмжээ авч үзэв. Тухайлбал, ахмад настанд олгох тэтгэвэрийг дэс дараалалтай байнга нэмэгдүүлэх, ахмад дайчдад түлээ нүүрс, орон сууцны хөлсний хөнгөлөлт үзүүлэх, нийслэл, томоохон хотуудад ахмадуудад зориулсан дэлгүүр байгуулах, орон сууцыг хөнгөлөлттэй үнээр хувьчлах, Хараагийн Тарни амралтыг нийгмийн халамжийн газарт харъяалуулан ахмадуудад үйлчлэх, ахмад дайчдад нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх, “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөтөлбөр” батлах, Олон улсын ахмадын настны жил болон жил бүрийн X сарын 1-нийг Ахмадын өдөр болгон тэмдэглэх зэрэг олон чухал арга хэмжээ авсан билээ.

Монгол Улсын удаа дараагийн Ерөнхийлөгчид ахмадын байгууллага, өтгөс буурай нарын тухайд байнга анхаарч, хайр ивээлээ өгч ирэв. Үүнд:

- Анхны Ерөнхийлөгч П.Очирбат ахмад настнаа хүндлэн дээдэлж, төрийн бодлого, шийдвэр боловсруулахад тэдний хүч, мэдлэгийг ашиглах, уламжлалт ёс заншлаа сэргээн хөгжүүлэх талаар тусгай айлдвар гаргаж байв.

- Хоёр дахь Ерөнхийлөгч Н.Багабанди “Монгол Улсын түүхийг шинээр туурвин хэвлүүлэх тухай” (1999), “Морин хуураа дээдлэн дэлгэрүүлэх тухай”(2002), “Монголын нууц товчоог мөнхөд эрхэмлэн дээдлэх тухай” (2004), “Уртын дуугаа өвлөн дэлгэрүүлэх тухай” (2004) зэрэг зарлиг буулган, өөрийнхөө дэргэд түүх, ёс заншлын зөвлөл ажиллуулж, ахмад настны тухайд төр, засгаас явуулах үйл хэрэгт санал, зөвлөгөө өгсөн тусгай ном бичиж тараажээ.

- Монгол улсын өдгөөгийн Ерөнхийлөгч Н.Энхбаяр 2005-2009 оны бодлого, үйл ажиллагааныхаа хөтөлбөрт: "...ахмад үеийнхээ нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бодлого, үйл ажиллагааг (11,201) ивээлдээ авахаар тусгаж, "Буурал түүхийн жимээр" аялалд оролцон, түүх, соёлын асуудалд бүх нийтийн анхаарлыг төвлөрүүлж, 2006 оны IV сард өөрийнхөө дэргэд Ахмадын зөвлөлийг байгууллаа. Ийнхүү Монголын төр түүхийн янз бүрийн шатуудад өтгөс дээдсээ хүндэтгэн халамжилж, тэднийхээ арвин баялаг туршлага, нөр их мэдлэгийг үнэт өв хэмээн үзэж, дээдэлж иржээ. Эцэст нь төр засгийнхаа анхааралд нэгэн зүйл толилуулахыг хүсч байна.

Эдүгээ төрийн эрх барьж, хууль тогтоож буй дээд байгууллага-УИХ-ын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, тодорхой хэмжээнд хяналт тавих механизмыг бий болгох шаардлагатай байна. Үүнд парламентын арвин баялаг туршлагатай Их Британийн Лордын танхимын ажиллагаанаас үлгэр авч болох юм. Одоо цөөн тооны хүмүүс үе залгамжилдаг, дийлэнх олонхи нь төр, нийгмийн ахмад зүтгэлтнүүдээс бүрддэг болжээ. Тэд цалин авдаггүй, харин хуралдах үедээ тодорхой хэмжээний урамшуулал авдаг. Тэдний шийдвэрийг доод танхим хүлээж авахгүй байх эрхтэй. Харин практик дээр парламентын доод танхим ихэнхдээ тэдний шийдвэр, зөвлөмжид хүндэтгэлтэй ханддаг ажээ. Лордын танхимын гишүүн байна гэдэг нэг талаас ахмад зүтгэлтнүүдэд нэр төр, хүндэтгэлийн механизм болж өгдөг, нөгөө талаас төр ахмад үеийнхээ арга туршлага, нөр их мэдлэгийг ашиглах өргөн боломж нээн өгдөг байна. Манайд ийм танхимийг Их хуралдайн хэлбэрээр байгуулж, төрийн бодлого, үйл ажиллагаанд ашиглаж болох юм. Тэнгэрт оготнын дуу үл хүрэх боловч өчүүхэн биеэ үл голон ийм санал дэвшүүлж байгааг минь дэмжинэ хэмээн найднам.

Резюме: В этой статье исследуется соотношение Монгольского государства и старого поколения, роль старых поколения в истории Монголии. В работе использован широкий круг источников, и прежде всего архивные материалы.

Эшлэл, зүүлт

1. Рашид-Аддин. Судрын чуулган. I дэвтэр. (Ц.Сүрэнхорлоогийн орчуулга) УБ.2002
2. Лувсанданзан. Алтан товч
3. Монголын нууц товчоо. (Сонгомол эх) УБ., 2005
4. Ш.Нацагдорж. Чингис хааны цадиг. УБ.1991

5. В.Инжаннаши. Хөх судар. III дэвтэр. УБ.2005
6. Ц.Дамдинсүрэн. Монголын уран зохиолын дээж зуун бэлэг оршивой. т.44
7. Богдын лүндэн. УБ.2002
8. МУУТА. ф-11, д-1,хн271
9. МУУТА ф-13, д-67, хн.109
10. Г.Цэдэвдорж. Монголын ахмадын байгууллагын түүхэн замнал. УБ. 2006
11. Н.Энхбаяр. Хөгжлийн төлөө зүтгэл, хүний төлөө сэтгэл. I (хэлсэн үг, илгээлт, мэндчилгээний эмхэтгэл) УБ.2005